



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 96

Дархан

“Дархан Үйлдвэрлэл технологийн парк”
ОНӨААТҮГ-ын дүрэм батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3.”ж”, 20 дугаар зүйлийн 20,1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д даалгасугай.

ДАРГА



С. НАСАНБАТ

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2020 оны 12 дугаар сарын 07 -ны өдрийн
№ дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

“ДАРХАН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Дархан үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл, удирдлага, бүтэцсзохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.
- 1.2. “Дархан үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /цаашид “үйлдвэрийн газар” гэх/ нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.
- 1.3. Үйлдвэрийн газрын нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль, Нэгдсэн төсвийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдөнө.
- 1.4. Үйлдвэрийн газар нь аймгийн ИТХ-аас тогтоосон бүс газруудад үйлдвэрлэл байгуулах, хөгжүүлэх, дэвшилтэт технологи, импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ХОЁР. ГАЗРЫН ОНООСОН НЭР

- 2.1. Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Дархан үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, товчилсон нэр нь “ДҮТП-ОНӨААТҮГ байна.
- 2.2. Байршил нь Дархан-Уул аймаг, Дархан сум, 10 дугаар баг, DBS телевизийн байр, 3 давхарт, 301 тоот байх бөгөөд хаягыг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БЭЛГЭДЭЛ, ТЭМДЭГ

- 3.1. Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг илтгэсэн бэлгэдэлтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 3.2. Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.
- 3.3. Тэмдгийг үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагын итгэмжлэгдсэн этгээд хариуцна.
- 3.4. Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь бэлгэдэл, тэмдгийн загварыг баталж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг эдэлнэ.

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 4.1. Үйлдвэрийн газрын эрхэм зорилго нь: Бид Монголдоо дэлхийн түвшний өндөр технологийг нэвтрүүлсэн парк байна.
- 4.2. Үйлдвэрийн газрын зорилго нь: Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл, Мэдээлэл, Агро, Био, Нано төнхологийн паркуудыг цогц байдлаар хөгжүүлнэ.
- 4.3. Үйлдвэрийн газрын зорилт нь:
 - 4.3.1. Шинжлэх ухааны судалгаа, туршилт явуулж, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
 - 4.3.2. Байгаль орчинд халгүй технологи нутагшуулах
 - 4.3.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлснээр нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх,
 - 4.3.4. Үйлдвэрлэлүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
 - 4.3.5. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

ТАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- #### ЗУРГАА. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 6.1. Үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргын саналыг үндэслэн аймгийн Орон Нутгийн Өмчийн газар хянаж, аймгийн Засаг даргаар батлуулна.
 - 6.2. Үйлдвэрийн газрын даргыг аймгийн Засаг дарга, бусад ажилтныг Газрын дарга тус тус томилж, чөлөөлнө.

- 6.3. Үйлдвэрийн газрын байнгын ажилтнууд нь албан тушаалын тодорхойлолттой байх ба ажлын онцлог, шаардлагуудыг харгалзан мэргэжлийн хүмүүсийг тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэхээр гэрээгээр ажиллуулж болно.
- 6.4. Үйлдвэрийн газрын дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан байна.
- 6.5. Үйлдвэрийн газар нь улсын болон орон нутгийн хэмжээний хөгжлийн хөтөлбөр, Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-Уул аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Үйлдвэрлэл технологийн паркийн гишүүн байгууллагын хөгжлийн төлөвлөгөө болон өөрийн боловсруулсан ТЭЗҮ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулна.
- 6.6. Үйлдвэрийн газар нь дэвшилтэт технологийн тоног төхөөрөмжийн туршилт, судалгаа шинжилгээ, түүн дээр ажиллах мэргэжлийн ажилчдыг сургаж дадлагажуулах зорилго бүхий сургалтын баазтай байж болно.
- 6.7. Үйлдвэрийн газрын ажилтнууд нь газрын даргын өмнө ажлаа тайлагнах үүрэгтэй.
- 6.8. Үйлдвэрийн газар нь улсын болон орон нутгийн хэмжээний хөгжлийн хөтөлбөрүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг тусгуулах, тайлагнах үүрэгтэй.

ДОЛОО. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Тус үйлдвэрийн газрын дарга нь аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулсаны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах ба дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.1.1. Холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөөлөх
- 7.1.2. Үйлдвэрийн газрыг төлөөлж гэрээ, хэлцэл байгуулах
- 7.1.3. Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг хууль болон гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна.
- 7.1.4. Үйлдвэрийн газар нь дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эд хөрөнгө эзэмших, ашиглах,
- 7.1.5. Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журам, ажилтуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, тэдгээрийг томилох чөлөөлөх.
- 7.1.6. Байгууллагын дарга нь тухайн жилийн үйл ажиллагааны орлогоос хамаарч, цалингийн сангийн хэмжээнд ажилтнуудын цалинг тогтоох.

- 7.1.7. Санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтлүүлэн, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистик мэдээ тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах.
- 7.1.8. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үүний тулд үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх заавар, журам гаргаж биелэлтийг хангуулах.
- 7.1.9. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан аливаа нууцыг задруулахгүй байх, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх.
- 7.1.10. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, шагнаж урамшуулах, тэдний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.
- 7.1.11. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 7.2. Батлагдсан бүтэц орон тоонд нийцүүлэн ажилтануудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сэлгэн ажиллуулах.
- 7.3. Өөрийн эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон үйлдвэрийн зохион байгуулалт, техникийн асуудлыг шийдвэрлэх
- 7.4. Үйлдвэрийн газрын дарга нь эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

НАЙМ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАН

- 8.1. Үйлдвэрийн газрын орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
- 8.1.1. Өөрийн ажил үйлчилгээнээс олсон орлого
- 8.1.2. Банкны зээлийн эх үүсвэр
- 8.1.3. Орон нутгийн төсвийн дэмжлэг
- 8.1.4. Хууль тогтоомжоор тогтоогдсон бусад эх үүсвэр
- 8.2. Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.
- 8.3. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг дарга, нягтлан бодогч нар хариуцна.

ЕС. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 9.1. Үйлдвэрийн газрын дарга нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд, ажилтнууд нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.